

БАТЛАВ:
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА  **М.БАДАМСҮРЭН**

**БҮЙР НУУРЫН ЭРГИЙН ЭЛСНИЙ НҮҮДЭЛ, ЦӨЛЖИЛТӨӨС ХАМГААЛАХ
ОЙН ЗУРВАС, ХАШАА БАРИХ АЖЛЫН ДААЛГАВАР**

2024.01.03

Хэрлэн сум


Ажлын нэр, төрөл	Тайлбар
Ажил гүйцэтгэх аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулахад харгалзах үзүүлэлт	<p>Оролцох аж ахуйн нэгж, байгууллага: “Мод үржүүлэх, мод тарих, ойжуулах, ойг нөхөн сэргээх” чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, тарьц суулгацын нөөцтэй, ажлын туршлагатай аж ахуйн нэгж байна.</p> <p>Мэргэжлийн боловсон хүчин. Үүнд: - Ойн техник - Ойн инженер - Ойжуулагч</p> <p>Ажлын туршлага: Өмнө жилүүдэд хийсэн ойжуулалтын ажил болон адил төстэй бусад ажлын акт, тодорхойлолт, гэрээний хувийг хавсаргана. /нотлох баримтаар баталгаажуулсан байх/</p> <p>Стандартын шаардлага хангасан улиас, бургас /навчит/ модны тарьц, суулгацын нөөцтэй байна. /MNS:6141-2020 стандартад заасан 2-3 настай 1 дүгээр зэргийн суулгацыг ашиглана.</p> <p>Тоног төхөөрөмж: Мод тарих колесовын царил, жоотуу, хүрз, усалгааны ёмкость, хувин, усалгааны хоолой зэрэг багаж хэрэгсэл, техник тоног төхөөрөмжтэй байна. /техник тоног төхөөрөмжийн зураг бусад нотлох баримтаар баталгаажуулсан байх/</p>
Бэлтгэл ажил	<p>Ойжуулах ажлын технологийн картыг сум дундын ойн ангиар хянуулж, ойжуулалтад гаргасан старьц, суулгацыг 3 жилийн хугацаанд арчлан ургуулах, нөхөн тарих төлөвлөгөөг сум дундын ойн ангиар батлуулан технологийн карттай байна.</p> <p>Тарьц суулгацыг ачих буулгах, түр хадгалах технологи, горим мөрдсөн байна.</p> <p>Суулгацын нүхийг /MNS:6258-1:2020 стандартын дагуу бэлтгэнэ</p>
Үе шатууд	<p>Ойжуулалтын ажил нь бэлтгэл, ойжуулах, ойжуулсан талбайг хүлээлгэн өгөх, зөрчил, гологдол арилгах, тайлан боловсруулах, тайланг хэлэлцүүлэн хүлээлгэн өгөх, дараагийн жилийн арчилгаа хамгаалалт хийх гэсэн үе шатуудтай байна.</p> <p>Ойн ангийн инженер, байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагчаас арга зүйн заавар зөвлөгөө авч ажиллах;</p> <p>Тарих ажлыг 5 дугаар сард хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд нөхөн тарилтыг 10-р сарын 25-ний дотор хийж 11 дүгээр сарын 15-ний дотор тайлан боловсруулж хүлээлгэн өгнө.</p>


3/10


	<p>Талбайн хөрсийг боловсруулж мод тарих технологи мөрдөж тарьцыг 30 см гүнд тарилт хийх;</p> <p>Ойжуулалтын ажил гүйцэтгэхдээ:</p> <p>Хамгаалалтын ойн зурвасын хойд эгнээнд бургасны тарьц, суулгацаар мод хооронд 1.5 м, эгнээ хооронд 2 м зйтай нийт 4 эгнээ. 1 га талбайд 800 ширхээс доошгүй байхаар тооцож тарилт хийх/;</p> <p>Хамгаалалтын ойн зурвасын урд эгнээнд улиасны тарьц, суулгацаар мод хооронд 2 м, эгнээ хооронд 2 м зйтай нийт 4 эгнээ байна. /1 га талбайд 600 ширхээс доошгүй байхаар тооцож тарилт хийх/;</p> <p>Ойн зурvas байгуулсан талбайд мал бэлчээхийг хориглосон анхааруулга пайз 4, ажлын танилцуулга бүхий 2x2 м хэмжээтэй төмөр самбар 1 ширхгийг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2013 оны А-96/71 тушаалын хавсралт журмын дагуу тэмдэгжүүлтийг байрлуулна.</p>
Үндсэн ажил	<p>Төмөр төрон хашаа</p> <ul style="list-style-type: none"> Хашаа нь ижил бурдэл хэсэгтэй байна: Өндөр 1.5 м, урт 4100 м / хашааны хэмжээ 50x2000 м нийт 10 га / Хашааны доод талаар мал, мэрэгч гамттан, орхооргүй хамгаалтын 5х5 мм тортой байна. Хашааны бурдэл хэсэгт, хурц узүүртэй хүн амьтан бэртэхээр зүйлгүй, тэгш гадаргуутай байна. Хашаа нь салхины хурд, цаг агаарын ачааллыг даахуйц бат бөх, тогтвортой байна. <p>Хашааны шон</p> <ul style="list-style-type: none"> Шонгийн өндөр: 2 м Шонгийн далавчны зузаан: 1,8-2 мм Шонгийн далавчны нүхтэй талын урт: 3 см Хашааны шонг газарт 50 см гүн сүүлгана. Шон 20 см тутамд төр бэхлэх нүхтэй байна. Торыг шонд “цэгээ уяа” –гаар бэхэлж тогтооно (чансаа уяа). <p>Тулгуур шон</p> <ul style="list-style-type: none"> Тулгуур шонгийн диаметр: 40 мм-с багагүй Тулгуур шонгийн өндөр: 2,0 м Тулгуур шонгийн хананы зузаан: 2,5-3 мм 20-30 м тутамд нэг тулгуур шон хийнэ. <p>Хашааны бэхэлгээ</p> <ul style="list-style-type: none"> Торны дээгүүр шон хооронд нэг эгнээ 3 мм цайрdsан төмөр утсаар бэхэлгээ хийж цайрdsан төмөр чангалаагчаар бэхэлнэ. Шон хоорондын торны гадна талд 3 мм диаметртэй төмөр утсаар X бэхэлгээ хийнэ. <p>Машини орж гарах хаалга</p> <ul style="list-style-type: none"> Машини хаалганы урт 4 метр, өндөр нь 1,8 м хаалганы шонг Ф80 мм-н тан трубагаар хийнэ. Хаалганы гадна рамыг 40x20 мм-ийн квадрат төмрөөр хийнэ. Хаалганууд сайн чанарын нугастай, цүйтэй, зүүдэн цоожтой байх ба дотор талдаа бат бэх замган түгжээтэй байна. Шонгийн газарт суух гүн 70 см-ээс багагүй байж BM150 маркийн бетоноор цутгаж шонг бэхэлж өгнө. Хаалга нь 5 мм-ийн цайрdsан төмөр төрон материалыар хийгдсэн

	<p>байна.</p> <ul style="list-style-type: none"> Машины хаалга 2 шон дээрээсээ чангалагч татуургатай байна. <p>Явган хүний хаалга</p> <ul style="list-style-type: none"> Хаалга нь 5мм-н цайдсан төмөр материалыар хийгдэнэ. Хаалганы гадна рам 40x20 мм-ийн квадрат төмрөөр хийнэ. Явган хүний хаалганы өргөн: 0,9-1 м Хаалганы өндөр: 1,8 м Хаалганд сайн чанарын нугас, түгжээ суурилуулна.
Үр дүн	<p>Ажлын үе шат бүрийг фото зураг, бичлэг хийж баталгаажуулан захиалагчид хүлээлгэн өгсөн байна.</p> <p>Ойжуулалтын ажлын хувийн хэргийг хөтлөн, талбайн зургийн хамт ажил хүлээн ажлын хэсэгт танилцуулсны дараа акт үйлдэнэ.</p> <p>Ойжуулалтын ажил хүлээлгэж өгснөөс хойш 3 жилийн хугацаанд гүйцэтгэгч аж ахуйн нэгж ургах чадваргүй болсон тарьц, суулгацыг авч нөхөн тарилт хийж, "арчлан" хамгаалах арга хэмжээ авсан байх;</p> <p>Аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэгт гүйцэтгэсэн ажлыг актаар хүлээлгэн өгнө.</p>

ХЯНАСАН:
**ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА**  **M.NЯМСҮРЭН**

ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН  **C.СОЛОНОГО**

ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН  **Э.МӨНХЧИМЭГ**

БОЛОВСРУУЛСАН:
**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ, ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГА**  **АРАНТУЛГА**